



119 Page



120 Page



121 Page

Гидеон

-Gideon-

Тайлбарлагч Израильчууд Бурханы өмнө гэм нүгэл хийн, хуурамч шүтээн шүтэж, муу зүйл их хийжээ. Бурхан Израильчуудыг ухааруулахын тулд, Мидиан хүмүүсийг явуулан шийтгэж гэнэ. Мидианчууд долоон жилийн турш Израильчуудыг зовоожээ. Израильчууд газар тариалан эрхэлж, ургацаа хураах үед Мидианчууд дайран ирж бүгдийг нь булаан авдаг байв. Үүгээр ч зогсохгүй үхэр, хонь, илжиг гээд бүх хөрөнгийг нь булааж байлаа.

Ягаан эмэгтэй (өвдөг сөгдөн уйлж) Ий ий! Тэр хонь болохгүй ээ!! Битгий авч яваач дээ...

Сэлэртэй эр (Мидиан хүн) Энэ хонь биднийх!

Том эртэгтэй Тэр хүүгийн гарт байгаа зүйлийг булааж ав!!!!

Гуйлгачин (уйлангаа) Бидэнд идэх зүйл үнэхээр алга...биднийг харж үзээч дээ. Ий ий ий

Тайлбарлагч Өөрсдийнх нь гэм буруугаас болж Бурхан уурлаж, тэдэнд шийтгэл өгснийг Израильчууд ойлгожээ. Тэгээд Бурханд хандан биднийг авраач хэмээн залбирч эхлэв.

Тайлбарлагч Нэгэн өдөр, Гидеон Мидианчууд дайран ирж магадгүй гэж бодоод тэднээс нуухын тулд усан үзмийн том шахуурганд улаан буудайгаа цайруулж байлаа. Тэр үед тэнгэр элч Гидеон дээр иржээ.

Эмэгтэй Тэнгэр элч Эрэмгий дайчин минь, ЭЗЭН чамтай хамт байна! Чи Мидианчуудын гараас Израилийг аврагтун!

Тайлбарлагч Ихэд гайхсан Гидеон тэнгэр элчид ийнхүү хэлжээ.

Гидеон Эзэн минь, би хэрхэн яаж Израильчуудыг аврах билээ? Манай гэр бүл Манассе дотроос хамгийн дорой нь төдийгүй би гэрийнхээ хамгийн бага нь шүү дээ.

Тайлбарлагч Бурхан Израильчуудын залбирлыг сонсоод Гидеоныг сонгожээ. Гэвч аймхай Гидеон Бурханы үгэнд шууд итгэн дуулгавартай дагаж чадсангүй.

Гидеон Хэрэв Бурхан минь надаар дамжуулан Израилийг аврах гэж байгаа юм бол тэмдэг харуулаач! Үтрэмийн шалан дээр ноос тавиад хоноё. Маргааш өглөө зөвхөн ноосон дээр шүүдэр бууж, эргэн тойрны газрыг хуурай байлгаж өгөөрэй.

Тайлбарлагч Дараагийн өдөр болоход гайхалтай юм болжээ. Шалан дээрх ноос л норсон байсан бөгөөд газар нь хуурай байжээ. Гэсэн ч Гидеон эргэлзэж байлаа. Бурханаас дахиад тэмдэг гуйжээ.

Гидеон Бурхан минь, дахиад нэг л удаа тэмдэг үзүүлээч. Энэ удаа эсрэгээрээ ноосыг хуурай байлгаж, эргэн тойронд нь шүүдэр буулгаж өгөөч.

Тайлбарлагч Дараагийн өдөр Гидеоны хэлсний дагуу Бурхан үйлджээ. Гидеон ийнхүү Бурханд эргэлзэлгүй итгэжээ.

.....



122 Page

Тайлбарлагч Бурхан Гидеонд Мидианчуудтай тулалдах цэргүүдийг сонго гэж хэлсний дагуу тэрээр маш олон цэрэг цуглуулжээ. Тэгэхэд Бурхан ингэж хэлэв.

Бурхан Гидеон! Чамтай хамт тулалдахаар явах цэргүүдийн тоо маш олон байна. Та нар тулаанд ялвал Миний хүчээр ялсандаа баярлах биш, өөрсдийн хүчээр яллаа гэж бардамнах болно. Тиймээс чи цэргүүддээ айж байгаа нь гэртээ харь гэж хэл. Тэгээд цэргийнхээ тоог багасга.

Тайлбарлагч Гидеон цэргүүддээ Бурханы хэлсэн үгийг дамжуулаад айж байгаа нь гэртээ харь гэтэл арван мянган цэрэг л үлджээ.

.....

Бурхан Тэд бас л олон байна. Тэдгээр цэргүүдийг голын эрэг уруу дагуулж яв. Би тэднийг сорих болно.

Тайлбарлагч Гидеон цэргүүдийг голын эрэг уруу дагуулж яваад ус уулгав. Тэгэхэд Бурхан нохой шиг хэлээрээ ус долоогчдыг өвдөглөн суугаад ус ууж байгаа хүмүүсээс салга гэжээ. Ингээд тэднээс үлдсэн цэрэг нь гурван зуу байлаа.

.....



123 Page

Тайлбарлагч Тэр шөнө Бурхан Гидеонд хэлжээ.

Бурхан Бос, тэр хуаран уруу оч.

Тайлбарлагч Гидеон гурван зуун цэргээ дагуулан дайсны байгаа газарт тойрон буужээ. Гидеон цэргүүддээ нэг гарт нь эвэр бүрээ, нөгөө гарт нь хоосон ваар бариулж, ваарны дотор бамбар хийлгэв. Орой болмогц Гидеон болон бүх цэргүүд хамтдаа эвэр бүрээг үлээн, ваарыг цохиж хагалан бамбараа барин хашхирчээ.

Цэргүүд ЭЗЭНий төлөө, Гидеоны төлөө!

.....



124 Page

Тайлбарлагч Энэ чимээг сонссон Мидиан цэргүүд цочин гайхжээ. Тэд айн сандарсандаа бие биенийгээ хөнөөчихөж гэнэ. Ийнхүү Бурханы тусламжтайгаар Гидеоны удирдсан гурван зуун цэрэг маш олон Мидиан цэргүүдийг ялжээ.

Цэргүүд Мандтугай! Мандтугай!



125 Page